



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/587

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн “Эрүүл өрх” өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,527,400.0 /гурван сая таван зуун хорин долоон мянга дөрвөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн “Эрүүл өрх” өрхийн эрүүл мэндийн төв /М.Алтанхуяг/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 933,600.0 /есөн зуун гучин гурван мянга зургаан зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 8 нэр төрлийн 2,593,800.0 /хоёр сая таван зуун ерэн гурван мянга найман зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн “Эрүүл өрх” өрхийн эрүүл мэндийн төв /М.Алтанхуяг/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115 5 01591

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 12 дугаар
сарын 12 өдрийн 4/1 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, "Эрүүл өрх" ӨЭМТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХК-ын хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж										
1	Гүйлтийн зам	9	ш	1	315,000.00	315,000.00	315,000.00	-	Резин нь сунаж, ашиглах боломжгүй болсон.	татах
2	Жийдэг унадаг дугуй	9	ш	1	268,000.00	268,000.00	268,000.00	-	Дөрөө, эд ангиуд нь хугарч эвдэрсэн.	татах
3	Хүчний дасгалын төхөөрөмж	10	ш	1	435,000.00	435,000.00	435,000.00	-	эд ангиуд нь эвдэрсэн.	татах
4	Хэвлийн булчин чангалагч	9	ш	1	90,000.00	90,000.00	90,000.00	-	Төмөр рам нь хугарсан.	татах
5	Товруутай цагираг	10	ш	1	25,000.00	25,000.00	25,000.00	-	Хугарч эвдэрсэн.	татах
6	Суурин даралтын аппарат	8	ш	1	850,000.00	850,000.00	850,000.00	-	Эвдэрсэн, сэлбэг хэрэгсэл олдохгүй.	татах
7	Процессор	7	ш	2	270,000.00	540,000.00	540,000.00	-	Эд ангиуд нь шатаж, эвдэрсэн.	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн				8		2,523,000.00	2,523,000.00	-		
Тавилга, эд хогшил										
8	Бичгийн ширээ	13	ш	4	210,900.00	843,600.00	843,600.00	-	Шургуулганууд эвдэрсэн, будаг халцарч өнгө үзэмжгүй болсон.	устгах

9	Компьютерийн ширээ	13	ш	1	70,800.00	70,800.00	70,800.00	-	Рам нь хугарсан, эвдэрсэн.	татах
Тавилга, эд хогшлын дүн				5		914,400.00	914,400.00	-		
Программ хангамж										
10	Өмчийн программ	8		1	90,000.00	90,000.00	90,000.00	-	Ашиглахаа больсон.	устгах
Программ хангамжийн дүн				1		90,000.00	90,000.00			
Нийт дүн				13		3,527,400.00	3,527,400.00	-		
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө					933,600.00					
Татан төвлөрүүлэх хөрөнгө					2,593,800.00					
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/										